



УЛААНБААТАР ХОТЫН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2 ДУГААР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ОРШИХ “МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024  
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

2024 он

## ГАРЧИГ

<b>НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....</b>	<b>3</b>
1.1 Төслийн нэр: .....	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгч: .....	3
1.3 Төслийн товч танилцуулга.....	3
<b>ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ.....</b>	<b>6</b>
2.1 Хүчин чадал.....	6
2.2 Тоног төхөөрөмж .....	7
<b>ГУРАВ. ХОГ ХАЯГДАЛ .....</b>	<b>7</b>
3.1 Хатуу хог хаягдал.....	7
3.1.1 Ахуйн хэрэглээнээс гарах энгийн хог хаягдал .....	8
3.1.2 Үйлдвэрлэлээс гарах энгийн хог хаягдал.....	8
<b>ДӨРӨВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ТОВЧЛОЛ...9</b>	<b>9</b>
<b>ТАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ</b>	
<b>ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....</b>	<b>11</b>
5.1 Хамрах хүрээ: .....	12
5.2 Зорилго .....	12
5.3 Зорилт.....	12
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	
Хүснэгт 1 Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж .....	7
Хүснэгт 2 Үйлдвэрийн технологийн хатуу хог хаягдлын хэмжээ .....	8
Хүснэгт 3 Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл.....	11
Хүснэгт 4 2024 оны БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн.....	12
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	
Зураг 1 Төслийн талбайн байришлын зураг.....	3
Зураг 2 Компанийн түүхэн замнал.....	4
Зураг 3 Үйлдвэрийн гадна байдал .....	6
Зураг 4 Зоорь агуулахын хэсэг .....	6
Зураг 5 Оффисийн орчны хог ангилан ялгах сав байршуулсан байдал .....	8
Зураг 6 Хаягдал яс хадгалалт, нохойн хоол хөлдөөн бэлтгэсэн байдал.....	9
Зураг 7 Төсөл хэрэгжиж буй талбай, .....	9
Зураг 8 Өмнөх байдал /2021 оны 3-р сар/.....	10
Зураг 9 Дараах байдал /2021 оны 7-р сар/ .....	10
Зураг 5 Оффисын хог хаягдлын зураг.....	8
Зураг 6 Хаягдал яс хадгалалт, нохойн хоол хөлдөөн бэлтгэсэн байдал.....	9
Схем 1 Үйлдвэрийн байрны ерөнхий бүтэц схем .....	5

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 1.1 Төслийн нэр:

Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн төсөл

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгч:

“Траст Трейд” ХХК-ийн “Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр” төслийн байршил Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 2-р хороонд байрладаг. Эзэмшлийн газрын нийт хэмжээ нь 1566м<sup>2</sup> талбайд байрлаж байна.

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:** “Траст Трейд” ХХК

**Улсын бүртгэлийн дугаар:** 9011002092

**Регистрийн дугаар:** 2610604

**Төсөл хэрэгжүүлэгч газрын хаяг:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 2-р хороо Доржийн гудамж-44 тоот

**Утас:** 99112710, 99097502

**Төсөл хэрэгжих талбайн байршил:** БЗД, 2-р хороо,



Зураг 1 Төслийн талбайн байршилын зураг

### 1.3 Төслийн товч танилцуулга

**Алсын хараа:** “Бэлчээрийн малын өгөөжийг дэлхийд таниулна”


**Компанийн эрхэм зорилго:** “Баталгаат махан хүнс үйлдвэрлэлийг хөгжүүлж, хэрэглэгчийн цагийг хэмнэсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан аз жаргалыг түгээнэ”

Компанийн философи: “Сэтгэлээ шингээнэ.”

**Компанийн үнэт зүйлс:**

- Итгэл: Хэрэглэгч, харилцагчийн итгэлийг бид дааж ажиллана.

- Ёс зүй: Хуулийн хүрээнд ажиллаж, улс орны хөгжилд бүхий л чадлаараа хувь нэмрээ оруулна.
- Мэдлэг: Мэдлэг, мэдээллийг хурдасгуур болгон ашиглаж, бусдад хуваалцан хамтдаа хөгжинө.
- Хандлага: Ажилтан бүр хийх ажилдаа сэтгэлээ шингээн, ажлын байр нь баяр баяслыг төрүүлэхүйц байна.



Зураг 2 Компанийн түүхэн замнал

**Хүний нөөц:** Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад нийт 169 ажилтан ажиллаж байна.

Схем 1 Үйлдвэрийн байрны ерөнхий бүтэц схем



“Траст трейд” компани нь 2000 онд хиам, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гадаад, дотоод худалдаа гэсэн үйл ажиллагааны чиглэлтэйгээр байгуулагдсан. 2013 оны байдлаар хоногт 15 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй, хүнсний үйлдвэрийн шаардлагад нийцсэн үйлдвэрийн байртай, гахайн аж ахуйтай болон өргөжсөн.



Зураг 3 Үйлдвэрийн гадна байдал

Монгол Улсын Засгийн газраас батласан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-т “Мах бэлтгэн хадгалах хөргүүртэй зоорь” төслөөр оролцон 2 тэрбум гаруй төгрөгний хөрөнгө оруулалттай, хүнсний үйлдвэрийн байрны стандартын шаардлагуудыг бүрэн хангасан, НАССР-ын шаардлагад нийцсэн, эрүүл ахуйн тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон “Траст Мийт” ангилсан махны үйлдвэрийг 2014 онд ашиглалтанд оруулсан. Манайх стандартын шаардлага хангасан агуулахтай мах боловсруулах үйлдвэр бөгөөд түүхий эдээ стандартын шаардлага хангасан мал төхөөрөх үйлдвэрээс бэлтгэн, хамтран ажилладаг.

## ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

### 2.1 Хүчин чадал

Хоногт 10 тонн мах шулж ангилах, савлах хүчин чадалтай махны үйлдвэр нь тус бүр нь 200 тоннын багтаамжтай -18 хэмд хөргөх 4 хэсэг бүхий хөргүүртэй агуулах, 200 тоннын багтаамжтай гэсгээлтийн өрөө, 40 тоннын багтаамжтай -38/-45/ хэмтэй гүн хөлдөөх зоорьтой.



Зураг 4 Зоорь агуулахын хэсэг

Мөн түүнчлэн бактерлоги болон химийн шинжилгээ хийх иж бүрэн лаборатори дотооддоо ажилладаг бөгөөд MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаадлагыг ханган итгэмжлэгдсэн уг лабораторийн шинжилгээний үр дүн нь Азийн 16 оронд хүчин төгөлдөр хүлээн зөвшөөрөгддөг.



## 2.2 Тоног төхөөрөмж

Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг ОХУ, Герман, Солонгос, Хятад, улсуудад үйлдвэрлэсэн том болон жижиг оврын тоног төхөөрөмжүүдээр тоноглон.

Хүснэгт 1 Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж

Нэр төрөл	Тоо ширхэг	Ашиглалтанд орсон он	Хүчин чадал
Тээврийн хэрэгсэл			
Хөргүүртэй автомашин	10	Probox-2008; fuso-2009; Mighty-2-2010 bongo-2014; Frontier-2016	Toyote probox-500кг Mitsubishi Fuso Center-5 тн Hyundai Mighty 2.5-3.0 тн Kia Frontier -1.4тн Kia Bongo 1.4 тн
Угаалгын машин	1	2020	GDZ-30G-380 Вольт, цахилгааны зарцуулалт 27,3вт, 940*870*590 овортой
Хатаагч	1	2020	КН4001А-220 вольт 24 Вт
Махны үйлдвэр			
Цэвэр бохир усны шугам	5	2013	200см, 50см, -н диаметртэй шугам
Усан банн хутга ариутгагч	1	2015	SK-14U 220вольт нэг удаад 14 хутга 2 мусот ариутгана.
Гэрлээр хутга ариутгагч	11	2013-2020	SK-15U 220вольт нэг удаад хутга мусот ариутгана
Вакуумны машин	2	2013	Вакуумдах дээд температур-2000С Вакуумдах чадал-10м3/цаг
Махны машин	1	2010	CLE660N-380 вольт 800х1200х1200 хэмжээ овортой
Махны өлгүүр зам	116м	2015	15тн
Металл илрүүлэгч	3	2010-2020	-5м/мин-500м/мин минутанд дамжуулж чадах хурдны хэмжээ метрээр доод тал нь 0,2-0,5 мм хэмжээтэй металл илрүүлэх
Хиамны үйлдвэр			
Вакуум кутер	1	2010	ZZB-200II-380 вольт,2480*2080*1950 хэмжээтэй цагт 85,27кв,
Шарах камер	4	2010-2020	QZX-500 380 вольт 1475*2235*2500 хэмжээтэй
Автомат шприц	3	2010	ZKG-6500-380 вольт, 1360*910*1785 хэмжээтэй, бункерийн хүчин чадал 220л зарцуулагдах эрчим хүч 5,95кв
Мах цавчигч	1	2012	DRQ-1000-380 вольт, 1920*892*1460мм хэмжээтэй
Мөсний машин	1	2007	BER-50-380 вольт, 1375*830*1150мм хэмжээтэй, цагт 40-50кг 4,55вт
Сав угаагч	1	2014	Fux-c-380 вольт, 992*3000*1474мм хэмжээтэй
Холигч машин	1	2015	ZKJB-650-380 вольт, хайрцагны багтаамж 650литр

## ГУРАВ. ХОГ ХАЯГДАЛ

### 3.1 Хатуу хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас энгийн хог хаягдал гарна. Энгийн хог хаягдал нь 2 хэсэг буюу оффис, үйлдвэр гэсэн хэсгүүдээс гарна.

### 3.1.1 Ахуйн хэрэглээнээс гарах энгийн хог хаягдал

Ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хаягдлууд болох хоол хүнсний үлдэгдэл, материалын сав баглаа боодол цаас, ундааны лааз, шил, мод зэрэг хог хаягдлууд гарна.

Энгийн хог хаягдал - Төсөл хэрэгжүүлэгчид энгийн хог хаягдлыг дараах байдлаар зайлуулах, мөрдөж ажиллаж байна.

- 1) “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” -ын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ажиллаж байна.
- 2) Хог хаягдлын ангилан ялгалтыг сайтар хийж, хогийн сав байршуулалт сайн, тэмдэг тэмдэглэгээг стандарт шаардлагад нийцүүлэн ажилтан албан хаагчдад шууд харагдахуйц байрлалд байрлуулж, ажилчид албан хаагчид тухайн шаардлага хангахад гар бие оролцон эмх цэгц сайтай ажиллаж байгаа нь суурь судалгаа, тандалтаар харагдаж байлаа. Зургаар харуулав.
- 3) Баянзүрх дүүргийн ТҮК-тай хамтран ажиллах гэрээтэй. Гэрээний дагуу тогтсон хугацаанд ахуйн хог хаягдлаа ачиж зайлуулдаг.



Зураг 5 Оффисийн орчны хог ангилан ялгах сав байршуулсан байдал

### 3.1.2 Үйлдвэрлэлээс гарах энгийн хог хаягдал


Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас цаасан хайрцаг, гялгар уут, хуванцар сав, бусад жижиг хог хаягдал зэрэг хаягдлууд гардаг. Дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт 2 Үйлдвэрийн технологийн хатуу хог хаягдлын хэмжээ

Үйлдвэрийн нэр	Хаягдлын төрөл	Хаягдлын хэмжээ/кг/	Хаягдал зохицуулалт
Махны үйлдвэрийн хог хаягдал	Цаасан хайрцаг	1716	Экопак цаасан хайрцагны үйлдвэр
	Гялгар уут	224	Эко сити селешн компанид
	Дахин боловсруулах боломжгүй гялгар уут	1950	ТҮК
	Хаягдал яс	2100	Промон Трейд ХХК
	Хаягдал мах	9	Нохойн хоол
Хиамны үйлдвэрийн хог хаягдал	Цаасан хайрцаг	180	Экопак цаасан хайрцагны үйлдвэр
	Гялгар уут	450	Эко сити селешн компанид
	Дахин боловсруулах боломжгүй гялгар уут	2340	ТҮК

Үйлдвэрээс гарч байгаа хог хаягдлыг дахин ашиглах тал дээр төсөл хэрэгжүүлэгч нь анхааран ажиллаж байна. Жишээлбэл: хаягдал ясыг гэрээт байгууллагад нийлүүлэн дахин боловсруулалтад оруулдаг, хаягдал махны цөвдлийг хайрцаглан хөлдөөж “Нохойн хоол” болгоод өөрийн борлуулалтын сүлжээгээр худалдаалдаг гэх мэт. Эдгээр хаягдлыг зориулалтын хөлдөөх агуулахад хадгалдаг. Хаягдлын нөхцөл байдлыг дараах зургаар харуулав.





Зураг 6 Хаягдал яс хадгалалт, нохойн хоол хөлдөөн бэлтгэсэн байдал

Харин бусад хог болох цаасан хайрцаг, гялгар уут, хуванцар сав зэргийг ангилан ялгалт хийж дахин боловсруулах үйлдвэр болон ТҮК-нд хүлээлгэн өгдөг байна.

#### ДӨРӨВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ТОВЧЛОЛ

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо *магадлан жагсаах* аргыг ашиглаж, үр дүнг байгаль орчин, нийгмийн бүрдэл хэсэг бүрээр үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, эрчим, үр дагавар зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх байдлыг үзүүлдэг. “Траст трейд” ХХК-ны “Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр” төслийн талбай нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт 1,5 га талбайд байрлаж байна.



Зураг 7 Төсөл хэрэгжиж буй талбай,

Төслийн талбай нь Баянзүрх дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт, үйлдвэрийн зориулалттай талбайд байрлаж байна. Газрын гадаргын төрх байдал нь үндсэндээ байгалийн унаган төрх байдлаа алдсан, хүн, техникийн нөлөөгөөр элэгдэл, эвдрэлд өртсөн байдалтай байна. Одоогийн байдлаар төсөл хэрэгжих 1.5га талбай бүрэн хатуу хучилттай ба хашаанаас төв зам хүртэлх 300м хатуу хучилттай замаар холбогдсон.

Үйлдвэрийн орчны зам талбай бүрэн хатуу хучилттай байна. Төслийн эзэмшил газрын 15 хүртэлх хувьд ногоон байгууламж бий болгосон.



Зураг 8 Өмнөх байдал /2021 оны 3-р сар/



Зураг 9 Дараах байдал /2021 оны 7-р сар/

Ногоон байгууламжийн тохижилт, зүлэгжүүлэлтийг хийж, дотоодын ажилчдын машины зогсоолыг тоосжилт үүсэхээс хамгаалж хайрга дэвсэж тэшглэсэн байна.

Ерөнхий үнэлгээнд тусгасаны дагуу төслийн байршилтай холбоотой асуудлыг тодруулах, тэдгээрийн төсөлтэй холбоотой байх шалтгааныг авч үзсэн бөгөөд тэдгээрээс төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна. Төсөл хэрэгжүүлэгчийн газар эзэмшил нь 2021 онд 15 жилийн хугацаатай сунгагдсан байна.

#### **Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл:**

Траст трейд ХХК-ийн “Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр”-ийн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнгүүдийг нэгтгэх нь байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүдийг тодорхойлох, төслийн үйл ажиллагааны явцад өртөгдөх байгаль орчны болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсүүд, түүн дэх нөлөөллийн цар хүрээг тогтооход чиглэгддэг. Энэхүү нэгтгэл нь БОННУ-ний тайлангийн үр дүнд үндэслэн эцсийн шийдвэрийг гаргах нөхцөлийг бүрдүүлдэг.

Тус төслөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн үр дүнгүүдийг нэгтгэн доорх хүснэгтэд үзүүлэв.

## Хүснэгт 3 Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
	Бага	Дунд	Их	Аюултай
<b>Байгаль орчин</b>				
Газрын гадарга, хэвлий	-3	0	0	0
Газрын гадарга ба газар доорх ус	-1	-1	0	0
Агаарын чанар	-2	-1	0	0
Хөрс	-3	0	0	0
Ургамал	-2	-1	0	0
Амьтан	-3	-1	0	0
Нийт нөлөөллийн тоо	14	4	0	0
Эзлэх хувь	77.8	22.2	0	0
<b>Нийгэм эдийн засгийн орчин</b>				
Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	0	+3	0	0
Хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	-2	-1	0	0
Түүх соёлын дурсгал	0	0	0	0
Нийт нөлөөллийн тоо	2	4	0	0
Эзлэх хувь	20	80	0	0
Ерөнхий дүгнэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 77.8 хувь нь бага, 22.2 % нь дунд зэрэг сөрөг нөлөөлөлтэй байна. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 50% нь Дунд зэрэг /эерэг/, 16.7 хувь нь дунд зэрэг сөрөг, 33.3 хувь нь Бага зэрэг сөрөг нөлөөтэй байна. Дээрх бүгдээс үзэхэд тус төсөл хэрэгжихэд байгаль орчинд болон нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл БАГА зэрэг сөрөг нөлөөтэй байна.			

Тайлбар: - Сөрөг нөлөө  
+ Эерэг нөлөө

### ТАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасаны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ



**5.1 Хамрах хүрээ:**

1. Манай төслийн хувьд хамрах хүрээгээ өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс хамгаалах, эвдрэл элэгдэлд орохоос сэргийлэн ажиллахаар төлөвлөнө.

**5.2 Зорилго**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, байгаль орчны төлөв байдлын тайланд тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

**5.3 Зорилт**

2. БОТБТ-гаар тодорхойлогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэн, бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах
3. Харьяа хороо, дүүргийн иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцлийг бүрдүүлж хамтран ажиллах
4. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана
5. Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хийж, ногоон орчныг нэмэгдүүлнэ.
6. Байгал орчны нөөцийн зарцуулалтыг шинжилж, ашиглалтын зардлаг бууруулна.
7. Хог хаядлыг бууруулж, 2-догч түүхий эдийн ашиглалтыг сайжруулна

*Хүснэгт 4 2024 оны БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн*

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Тухайн жилийн зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5 260
2	Нөхөн сэргээлт, зүлэгжүүлэх арга хэмжээ	3 200
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	
4	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	35 000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11 300
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	986
<b>Нийт</b>		<b>55,746.0</b>

## 1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хийн орчны агаарын бохирдуулахаас урьдчилан сэргийлэж автомашины утааны хэмжилт хийх	Тээврийн хэрэгсэл бүрт	ш	Үйл ажиллагааны зардалд	-	-	Жилд 1 удаа	<i>Агаарын тухай хууль, MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага</i>
		Хогийн цэгт дулааны улиралд ариутгал хийх.	Хог хаягдлын цэг	ш	20.0	6	120.0	5-9 дүгээр саруудад, сард 1 удаа	
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Үйлдвэрийн хашаа болон үйлдвэрийн хашааны гадаад зам талбайд тоосжилт үүсэхээс сэргийлж засах	Төслийн хүрээнд		2500.0	1	2,500.0	Тухай бүр	<i>Газар доорх усыг бохирдлоос хамгаалах: MNS3342:1982, Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/</i>
		Ахуйн болон технологийн хог хаягдлын цэгийг хатуу хучилттай хөрсөнд алдахгүй байхаар тохижуулах, ангилан ялгалтыг сайжруулэх	Төслийн талбайд		1500.0	1	1,500.0	Тухай бүр	
3	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Төслийн табайн орчимд зүлэгжүүлэлтийг хийх	Хог хаягдлын цэг		1500.0	1	1,500.0	5 сард	<i>MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ</i>
4	Газрын хэвлий	-	-		-	-	-	-	
<b>Нийт</b>							<b>5,620.0</b>		

**1.2 Нөхөн сэргээлт буюу ногоон байгууламж**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш/	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Нөхөн сэргээлт	Ундны усны эх үүсгэвэрийн талбай дээр ойжуулалт хийх "Хамтын төгөл" төсөлд хамтран оролцох	тухай бүр	50	15.0	2,700	4 болон 10 дугаар сард	<i>MNS 5914-2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага</i>
2		Төслийн талбайд цэвэрлэгээ хийн тохижилтонд сайжруулалт хийх	тухай бүр	2	3000.0	500	4, 5 дугаар сард	
<b>Нийт</b>						<b>3,200</b>		

**1.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө**

Төслийн талбай нь аймгийн төвд, суурьшлын бүсэд байрлах учир нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

**1.4 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохин байгуулалтын төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Тоног төхөөрөмжийн үзлэг оношлогоог хийх, техник ашиглалтын паспорт хөтлөх	Үйлдвэрт	Тухай бүр	-	-	Тухай бүр	<i>Гамигаас хамгаалах тухай хууль, 27.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай.</i>
2		Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Үйлдвэрт	1	150.0	150.0	1 удаа	
3		ХАБЭА-н сургалт /анхны тусламж үзүүлэх арга техник/ 45хүн*30мян.төг=1350.0мян.төг	Үйлдвэрт	1	30.0	1,350.0	1 удаа	<i>Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм</i>



№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
4		Ажилтныг хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хувцас, хамгаалах хэрэглэлээр хангаж ажиллах	Төслийн хэмжээнд	Тухай бүр	-	33,500.0	Тухай бүр ХАБЭА	
	<b>Нийт</b>					<b>35,000</b>		

#### 1.4 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Ахуйн хатуу хог хаягдал зайлуулах гэрээний дагуу тухай бүрт ачин зайлуулж байх	Төслийн хүрээнд	тухай бүр	480	12	5,760	Сар бүр	<i>Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,</i>
		Хог хаягдлын төрөл тус бүрээр ангилан ялгаж, түр хадгалах цэгийг хашаа хамгаалалт хийж тохижуулах	Төсөл хэрэгжих талбай	тухай бүр	-	-	3,500	2024 онд	
		Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажилчдад сургалт явуулах	Төсөл хэрэгжих талбай	1 удаа	-	1	ҮА зардлаар	1 удаа	
		Дахин ашиглагдах хаягдыг 2догч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх /Гялгар уут, хайрцаг, яс...гм/	Төсөл хэрэгжих талбай	тухай бүр	-	-	ҮА зардлаар	2024 онд	

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
		Дахин ашиглагдах хаягдыг 2догч түүхий эд болох болох хаягдал өөхөөр Халал саван үйлдвэрлэж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Төсөл хэрэгжих талбай	тухай бүр	-	-	ҮА зардлаар	2024 онд	
2	Технологийн буюу аюултай	Аюултай хог хаягдлын журам боловсруулах, гүйцэтгэх удирдлагаар баглуулах, мөрдөх	Төслийн хүрээнд	-	-	-	-		<i>Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам,</i>
		Аюултай хог хаягдлыг эх үүсгэвэр дээр шаардлагад нийцүүлж хадгалах, бүртгэл хөтлөх	Төслийн машин механизм	-	-	-	-		
		Аюултай хог хаягдлыг тусгай эрх бүхий байгууллагад эрх шилжүүлэх, дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах	Төслийн хэмжээнд	Гэрээнд заасны дагуу	170	12	2,040.00		
	<b>Нийт</b>						<b>11,300</b>		

### 1.5 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршиг суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, /мян.төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Дүүрэг, хороонд	Уулзалт, санал асуулга	БОМТ-ний хэрэгжилт болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	Жил бүрийн 11-р сар	200.0	Баримт бичгийн ажилтан	-
2	БОАЖЯ	Цаасан тайлангаар / цахим тайлан/	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	Жил бүрийн 12-р сар	-	Лабораторийн эрхлэгч	-
<b>Нийт</b>					<b>200.0</b>		

## ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Траст трейд” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгал орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

### Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /мян.төг/	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	2	3	4	5	6	7	8	
<b>Агаарын чанар</b>								
1.1	Агаарын бохирдлын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO) шинжилгээ хийлгэж байх /БОТЛ мэргэжилтэн хэлслэн хийлгэнэ. /	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 1-2 цэг сонгох. Үйлдвэр дотор, гадаах хашаанд	2 цэгээс хагас жилд 1 удаа	Жилд 2 удаа	80.0	160.0	Үйлдвэрийн цех тжс бүрээс шинжилгээ авах	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,
1.2	Агаарын тоосны (TSP, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> ) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		2 цэгээс хагас жилд 1 удаа	Жилд 2 удаа	85.0	170.0		MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
1.3	Дуу шуугиан, чичиргээ: үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		2 цэгээс хагас жилд 1 удаа	Жилд 2 удаа	45.0	90.0		MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
<b>Усны хяналт шинжилгээ</b>								
2.1	Технологид хэрэглэх цэвэр усны шинжилгээ – /Хими, микробиологи, хүнд металл/	цэвэр уснаас дээжлэх	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	95.0	190.0	-	MNS 6561:2015 Ариутгах татуургын хамжээнд нийлүүлэх хаягдал ус ТЕШ

2024 он

“ТРАСТ ТРЕЙД” ХХК-ийн хэрэгжүүлж буй Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 2-р хороонд байрлах “Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /мян.төг/	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	1	2	3	4	5	6	7	8
2.1	Технологиос гарах бохир усны шинжилгээ /бохир усны стандартын дагуу/	<i>бохир уснаас дээжлэх</i>	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	98.0	196.0	-	<i>MNS 6561:2015 Ариутгах татуургын хамжээнд нийлүүлэх хаягдал ус ТЕШ</i>
<b>Хөрсний бохирдол</b>								
3.1	Хөрсний шинжилгээ – Агро хими	<i>Төслийн талбайгаас</i>	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	45.0	45.0	1 цэгээс 3 дээж шинжилгээнд хамруулах	<i>MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2029 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ</i>
3.2	Хөрсний шинжилгээ – Хүнд металл /6 үзүүлэлт/				85.0	85.0		
3.3	Хөрсний шинжилгээ – Механик бүрэлдэхүүн				50.0	50.0		
<b>Амьтны аймаг</b>								
4.1	Амьтны аймаг	-	-	-	-	-	-	
<b>ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>						<b>986.0</b>		